



“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК

ХӨТӨЛ

**“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ИЙН
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**





| | |
|----------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| АЛСЫН ХАРАА | Бид Монгол Улсын Барилгын материал үйлдвэрлэлийн төв байна. |
| ЭРХЭМ ЗОРИЛГО | Төр, хувийн хэвшил, ард түмний тэгш өмчлөлтэй, ил тод, цахим засаглалтай, нээлттэй хувьцаат компани болж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнээр шударга өрсөлдөн, баялаг бүтээнэ. |
| ҮНЭТ ЗҮЙЛ | Манлайлал, хамтын хөгжил Хариуцлага, ёс зүй Найрсаг хүндэтгэлтэй Шилдэг бүтээгдэхүүн Шинэлэг үйлчилгээ |
| УРИА ҮГ | Хөгжил дэвшилд хөтөлнө |

ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

ЭРХЭМ БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРАА!

Тэртээ 1983 онд Монгол Улсын уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр”-ийг шохойгоор хангах зорилгоор үүсгэн байгуулагдсан манай цемент, шохойн үйлдвэр 40 дэх жилийнхээ босгон дээр ирээд байна. Өнгөрсөн 40 жилийн хугацаанд бид 7.5 сая тонн цемент, 1.6 сая тонн шохой үйлдвэрлэн борлуулж, Монгол Улсынхаа барилгын салбарын бүтээн байгуулалтад чамгүй их хувь нэмэр оруулжээ.

“Цемент шохой” ТӨХК нь өдгөө дулааны охин компаниа оролцуулан 820 гаруй ажилтантайгаар цемент, шохой, чулуунцар, дулаан, уулын цул үйлдвэрлэл явуулж, ил тод, цахим засаглалыг хөгжүүлж, бие даасан үйл ажиллагааны тогтолцоог хэвшүүлж, бизнесийн алтан зарчмаар харилцан ашигтай хамтран ажиллах, үйлдвэрүүдийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, шохойн үйлдвэрээ иж бүрнээр нь шинэчлэх зэрэг ажлыг ойрынзорилтоо болгон ажиллаж байна.

Бид ирэх он жилүүдэд Монгол Улсын Барилгын материал үйлдвэрлэлийн төв болох алсын хараатай байгаа билээ. Тиймээс үйл ажиллагаандаа олон улсын ISO стандартуудыг нэвтрүүлж, компанийн өрсөлдөх чадвар, үнэ цэнийг нэмэгдүүлэн, улмаар Хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болох зорилгодоо хүрч, үндэсний тэргүүлэгч компани болно гэдэгт итгэл төгс байна.



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хөтөлийн цемент, шохойн комбинатыг ББМҮЯ-ны сайдын 1983 оны 127 дугаар тоот тушаалаар цементийн үйлдвэр, шохойн үйлдвэр, уулын олборлох үйлдвэр, засвар механикийн контор, дулааны станц гэсэн бүтэцтэй анх байгуулжээ. 1984 онд шохойн үйлдвэрийн 1 дүгээр зуухыг 4 ээлжээр галлаж, үйл ажиллагаагаа эхлүүлснээр үйлдвэрийн хамт олон анхны бүтээгдэхүүнээ “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т нийлүүлсэн. 1986 онд цементийн үйлдвэрийн технологийн 1, 2 дугаар шугамыг Улсын комисс хүлээн авснаар цементийн үйлдвэрлэл эхэлсэн. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоол, Засгийн газрын 2015 оны 330 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 2015 оны 608, 617 дугаар тогтоолоор Төрийн өмчийн хороо нь “Бейзмент” ХХК-тай 2015 оны 10 дугаар сарын 14-ний өдөр 15/1а-2015 дугаартай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан. Уг гэрээний дагуу одоогийн “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ийн төрийн мэдлийн 100% буюу нийт 119,452,690 ширхэг хувьцааг “Өмчлөх эрхийн өр төлбөр төлөх” нөхцөлтэйгөөр “Хөтөл” ХХК (хуучнаар “Бейзмент” ХХК) шилжүүлэн өгсөн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 124 дүгээр тоот тогтоолоор “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай”, Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 330 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт”-д “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-тай холбогдох 15 дахь хэсгийг хассанаар “ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК нь төрийн өмчит компанийн статустай үйл ажиллагаагаа явуулж байна.



ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДАЛ



БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ

ЦЕМЕНТ:

Анх 1984 онд I зуухаа галлаж эхэлснээр Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй. Цементийн үйлдвэр нь өвлөөс бусад улиралд тасралтгүй 4 ээлжээр 24 цагийн турш үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд өнөөдрийн байдлаар Монгол Улсын MNS974:2008 ангиллын стандартын дагуу PPC-32.5, OPC-42.5, PC-42.5, PC-52.5 маркийн цементийг үйлдвэрлэж, эх орныхоо бүтээн байгуулалтад бүтээгдэхүүнээ 40 жил тасралтгүй нийлүүлэн ажиллаж байна.

PPC-32.5



PPC 32.5-15% - M-20 зэрэглэлийн бетонд өргөн ашиглагдах ба даац авахааргүй их хэмжээний масс бетон шал, ханын цутгалт, авто зам, төмөр хийц бүхий тэгш гадаргуутай барилгад өргөн ашиглагдана.

OPC-42.5



OPC 42.5 - M-30 зэрэглэл нь өндөр чанартай бетон гаргаж авахад ашиглана. Цементийг барилгын өргөн хэрэглээний зориулалттай төмөр бетон, угсармал хийц хэсэг, гүүр далан, цутгамал эдлэл болон барилгын зориулалттай ашиглагдана.

PC-52.5



PC 52.5 маркийн өндөр ангиллын портланд цемент нь их ачаалал авах гүүр, олон холбоос бүхий барилга, байгууламж буюу цаг агаарын хүйтэн сэрүүн бүсэд баригдах барилга, байгууламжид өргөнөөр ашиглагдана.

ШОХОЙ:

Шохойн үйлдвэр нь 1980 онд хуучнаар ЗХУ-ын техник, эдийн засгийн тусламжаар баригдаж, 1983 оны 12 дугаар сарын 11-нд I зууханд гал өгснөөр үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй. Тус үйлдвэр нь “Хөтөл-1”, “Хөтөл-2” ордыг түшиглэн уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын шохойн хэрэглээг хангах зорилгоор жилд 55,000 тонн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай, босоо 3 зуухтайгаар баригдаж ашиглалтад орсон. Шохойн үйлдвэр нь жилд 50,000-55,000 тонн шохойг дунджаар 75%-иас дээш идэвхжилтэй үйлдвэрлэж байна.

MNS347:2002 80%-иас доош идэвхжилтэй



Барилгын хэрэглээний шохой

MNS347:2002 80%-иас дээш идэвхжилтэй



Технологийн хэрэглээний шохой

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

| Мерийн дугаар | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|----------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө гүүнтэй адилтгах хөрөнгө | 6,043,794,423.40 | 2,358,841,938.83 |
| 1.1.2 | Дансны авлага | 2,317,913,402.89 | 2,456,467,142.23 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 1,021,049,927.31 | 3,194,298,726.53 |
| 1.1.4 | Бусад авлага | 12,921,614,074.29 | 13,820,834,908.71 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бараа материал | 19,239,758,176.89 | 35,341,886,570.86 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 2,479,869,949.47 | 4,153,244,422.95 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 546,192,946.00 | 546,192,946.00 |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 44,570,192,900.25 | 61,871,766,656.11 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 230,379,564,442.24 | 229,157,796,841.02 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 5,281,270,068.56 | 5,479,460,192.60 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 3,110,309,086.42 | 3,110,309,086.42 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 238,771,143,597.22 | 237,747,566,120.04 |
| 1.3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 283,341,336,497.47 | 299,619,332,776.15 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.1 | ӨР ТӨЛБӨР | | |
| 2.1.1 | Богино хугацаат өр төлбөр | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 2,897,890,289.78 | 9,140,244,319.57 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 72,815,486.00 | 72,815,486.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 12,642,450,074.75 | 17,048,404,894.87 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 0.00 | 624,104,838.61 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 16,372,618,946.34 | 16,372,618,946.34 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 3,952,807,965.76 | 3,211,505,036.42 |
| 2.1.1.9 | Нөөц / өр төлбөр / | 16,437,867.72 | 15,437,867.72 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 249,187,517.26 | 201,960,397.71 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.1.13 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 36,204,208,147.61 | 46,687,091,787.24 |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 41,916,835,529.58 | 41,916,835,529.58 |
| 2.1.2.2 | Нөөц / өр төлбөр/ | 2,213,391,285.66 | 2,213,391,285.66 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 3,703,657,012.83 | 3,703,657,012.83 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 275,738,820,300.00 | 275,738,820,300.00 |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 323,572,704,128.07 | 323,572,704,128.07 |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 359,776,912,275.68 | 370,259,795,915.31 |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Төрийн өмч | 0.00 | 0.00 |
| 2.3.2 | Хувийн өмч | 0.00 | 0.00 |
| 2.3.3 | Хувьцаа | 11,945,269,000.00 | 11,945,269,000.00 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0.00 | 0.00 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 420,000,000.00 | 420,000,000.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 41,284,046,790.95 | 41,284,046,790.95 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0.00 | 0.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 2,861,655,327.46 | 2,861,655,327.46 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | -132,946,546,896.62 | -127,151,434,257.57 |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | -76,435,575,778.21 | -70,640,463,139.16 |
| 2.4 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 283,341,336,497.47 | 299,619,332,776.15 |

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн | Өссөн дүн |
|---------------|-------------------------------------------------------------|-------------------|-------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 95,854,747,844.90 | 39,186,610,381.86 |
| 2 | Борлуулалтын өртөг | 72,497,327,147.76 | 28,266,562,818.67 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 23,357,420,697.14 | 10,920,047,563.19 |
| 4 | Түрээсийн орлого | 18,097,822.91 | 6,146,299.11 |
| 5 | Хүүгийн орлого | 0.00 | 0.00 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 802,456,050.33 | 334,202,683.81 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 2,272,825,405.96 | 1,333,475,196.31 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 3,218,947,957.00 | 2,508,207,089.18 |
| 11 | Санхүүгийн зардал | 1,490,937,241.46 | 0.00 |
| 12 | Бусад зардал | 1,972,886,041.97 | 850,507,334.79 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 10,760,355.52 | 8,585,097.46 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 16 | Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |
| 18 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 15,233,138,279.51 | 6,576,792,023.29 |
| 19 | Орлогын татварын зардал | 2,986,374,817.20 | 744,198,005.75 |
| 20 | Татварын дараах ашиг (алдагдал) | 12,246,763,462.31 | 5,832,594,017.54 |
| 21 | Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 12,246,763,462.31 | 5,832,594,017.54 |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.3 | Бусад олз (гарз) | 0.00 | 0.00 |
| 24 | Орлогын нийт дүн | 12,246,763,462.31 | 5,832,594,017.54 |
| 25 | Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 |



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| | Үзүүлт | Өмч | Энгийн хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----|------------------------------------------------------------------------|------|--------------------|------------------------|-------------------------------------|-----------------------------------|---------------------------|---------------------|--------------------|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 287,684,089,300.00 | 420,000,000.00 | 41,284,046,790.95 | 0.00 | 2,861,655,327.46 | -142,722,666,690.88 | 189,527,124,727.53 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | -341,613,600.00 | -341,613,600.00 |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 0.00 | 287,684,089,300.00 | 420,000,000.00 | 41,284,046,790.95 | 0.00 | 2,861,655,327.46 | -143,064,280,290.88 | 189,185,511,127.53 |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 5 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 6 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 7 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 12,246,763,462.31 | 12,246,763,462.31 |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 9 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 0.00 | 11,945,269,000.00 | 420,000,000.00 | 41,284,046,790.95 | 0.00 | 2,861,655,327.46 | -132,946,546,896.62 | -76,435,575,778.21 |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 0.00 | 11,945,269,000.00 | 420,000,000.00 | 41,284,046,790.95 | 0.00 | 2,861,655,327.46 | -132,946,546,896.62 | -76,435,575,778.21 |
| 12 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 14 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 5,770,752,057.54 | 5,770,752,057.54 |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | 2023 оны 6-р сарын 30-ээрх үлдэгдэл | 0.00 | 11,945,269,000.00 | 420,000,000.00 | 41,284,046,790.95 | 0.00 | 2,861,655,327.46 | -127,151,434,257.57 | -70,640,463,139.16 |

ТАТВАР ТӨЛӨЛТ

4,042,872,971 ТӨГРӨГ

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн | Өссөн дүн |
|---------------|----------------------------------------------------------------|--------------------|--------------------|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 41,358,828,264.38 | 41,358,828,264.38 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 41,259,279,643.95 | 41,259,279,643.95 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан гатвар | 40,941,216.54 | 40,941,216.54 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 58,607,403.89 | 58,607,403.89 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | -45,120,041,838.67 | -45,120,041,838.67 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | -10,498,836,827.35 | -10,498,836,827.35 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | -2,156,018,203.44 | -2,156,018,203.44 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | -14,933,499,202.62 | -14,933,499,202.62 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | -5,945,503,165.77 | -5,945,503,165.77 |
| 1.2.5 | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | -8,505,807,650.52 | -8,505,807,650.52 |
| 1.2.6 | Хүүний төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | -1,584,140,455.14 | -1,584,140,455.14 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | -1,496,236,333.83 | -1,496,236,333.83 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -3,761,213,574.29 | -3,761,213,574.29 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 67,675,992.26 | 67,675,992.26 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 0.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 67,675,992.26 | 67,675,992.26 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 0.00 | 0.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 0.00 | 0.00 |
| 2.3 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 67,675,992.26 | 67,675,992.26 |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 20,595,133.89 | 20,595,133.89 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| 3.1.4 | Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | 20,595,133.89 | 20,595,133.89 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | -12,010,036.43 | -12,010,036.43 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 3.2.5 | Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | -12,010,036.43 | -12,010,036.43 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 8,585,097.46 | 8,585,097.46 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -3,684,952,484.57 | -3,684,952,484.57 |
| 5 | Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,043,794,423.40 | 6,043,794,423.40 |
| 6 | Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,358,841,938.83 | 2,358,841,938.83 |

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л.НАРАНБААТАР

Лүндэгийн Наранбаатар нь уул уурхайн үйлдвэрлэлийн удирдлагын бакалавр, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй бөгөөд санхүүгийн удирдлагаар мэргэшсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт 20 гаруй жил ажилласан ба үүнээс 15 жилд нь удирдах албан үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай. Уул уурхайн салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлж, 200 гаруй компанийн ТЭЗҮ боловсруулсан. Австрали-Азийн уул уурхайн металлургийн институтийн гишүүн, Монголын эрдэс баялгийн эдийн засаг, менежментийн нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн.



ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА Н.БУЯН-ӨЛЗИЙ

ШУТИС-ийг Ашигт малтмалын баяжуулалтын технологич инженер мэргэжлээр бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн, мэргэшсэн инженер юм. 2005 оноос хойш уул уурхай, барилгын салбарт 18 жил ажиллаж байна.



ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА Ц.ИХБАЯР


МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр, магистрын зэрэгтэй дүүргэсэн. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, шүүхэд төлөөлөх эрхтэй юм. 2008 оноос хойш хууль зүйн салбарт 14 жил ажиллаж байна.




БИЗНЕС ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА Л.НЯМБАЯР

Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Гүрэн дээд сургуулийн Төрийн удирдлага магистрын зэрэгтэй. 2001 оноос бизнесийн удирдлагын чиглэлээр 21 жил ажилласан ба “Эрдэнэс Монгол”, “Монгол шуудан” зэрэг төрийн өмчийн компанийн Гүйцэтгэх удирдлагын багт ажилласан туршлагатай юм.

“ЦЕМЕНТ ШОХОЙ” ТӨХК-ИЙН БҮТЭЦ



АЖИЛЛАХ ХҮЧ



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Бид нийгмийн хариуцлагын хүрээнд өөрсдийн хөрөнгө оруулалтаар, хөтөлийн хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчныг бүрдүүллээ. ерөнхийлөгчийн санаачилсан "тэрбум мод" хөдөлгөөнийг дэмжиж, 2022-2027 он хүртэл нэг тэрбум төгрөгөөр мод тарьж, ногоон бүтээн байгуулалтыг дэмжихээр ажиллаж байна.



Ажиллагсдын идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх зорилгын хүрээнд **хөлбөмбөг, 3x3 сагсан бөмбөгийн талбай**г сэргээн засварлаж, хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД



СОВА ОРД

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэрт хэрэглэгддэг агууламж өндөртэй шохойн нөөцийг 18 жилээр нэмэгдүүлэх зорилгоор “Хөтөл-1” ордоос хууль бусаар тасалж авсан СОВА ХХК-ийн 31.5 га талбайн лицензийг Сэлэнгэ аймгийн Засаг даргад хандан, цуцлуулсан. Мөн уурхайн нөөцийг нэмэгдүүлж, хүчин чадлаа 2 дахин өсгөж, шохойн шинэ үйлдвэрийг тасралтгүй 50 жил ажиллуулах боломжтой 3D хэмжээст нөөцийн загвартай болсон.

Цемент, шохойн үйлдвэрийн 800 гаруй ажилчид, Хөтөлийн хотын 2000 орчим иргэн гарын үсэг зурж нэгдэн, лиценз цуцлуухаар шаардсан.

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

2023 оны I улирлын байдлаар техникийн 17.3, биологийн 11.2, дүйцүүлэн хамгаалах 23.8 нийт 52.3 га газарт нөхөн сэргээлт хийж, сум, орон нутагт хүлээлгэн өгсөн.



БИД МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ БАЙНА



www.khutulcement.mn